

Д. Цэдэв

**ЗӨВЛӨЛТ-МОНГОЛЫН ЦЭРГИЙН ТҮҮХЭН
ЯЛАЛТ**

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын нутгийн дорнод хэсэг дэх Халхын голын орчим 1939 онд Японы милитаристуудын өдүүлсэн түрэмгийлэл нь зарлаагүй дайн байсан юм.

Японы булаан эзлэгчид байлдааны ажиллагаа явуулахаар сонгож авсан газар нь тэдэнд олон талаар давуутай байсан бөгөөд төмөр, засмал зам болоод хангах бааздаа ойр, уух усаар элбэг газар байжээ. Гэтэл харин Зөвлөлт-Монголын цэрэгт газар нутгийн байдал нь тун ч тохиромжгүй байжээ. Халхын гол Улаанбаатар хотоос 1000 орчим км алс хол, тэндээс хамгийн ойр төмөр замын буудал 750 км хол зайтай, уг газар нь ил задгай тал газар байсныг юуны өмнө тэмдэглэх хэрэгтэй юм.

1939 оны 1-р сараас эхлэн Япон-Манжийн цэрэг БНМАУ-ын хил хязгаарыг байнга зөрчих болжээ. Тэр үеийн манай хэвлэлд мэдээлж байсан байлдааны мэдээ баримтаас үзэхэд 1939 оны 1-р сарын 16-наас мөн сарыг дуустал бараг өдөр бүр, 2-р сарын 8, 13, 16, 3-р сарын 17, 21, 22, 4-р сарын 5, 16, 5-р сарын 4-ний өдрүүдэд Япон-Манжийн доод тал нь 10, дээд тал нь 60 гаруй тооны зэвсэгт цэргүүд Халхын голын орчим Хайластын гол, Нуурын овоо зэрэг газруудаар манай хилийг зөрчин нэвтэрч хилчдийг буудах зэргээр өдөөн хатгалга хийж байжээ.¹

Японы дайнчид 1939 оны 5-р сарын 11-нд 250 шахам цэрэг, 5-р сарын 14-нд 300, 15-нд 200 цэрэг явуулж хил хязгаарыг зөрчиж Халх голын орчмоор тус улсын нутагт цөмрөн оржээ. БНМАУ-ын засгийн газар дээрх байдалтай холбогдуулан 1939 оны 5-р сарын 22-нд Япон, манжийн талд нот бичиг явуулж, түүндээ Япон-Манжийн цэрэг Баргын нутгаар манай улсын хил хязгаарыг зөрчиж үйлдсэн өдөөн хатгалгыг эрс эсэргүүцэн буруушааж удаа дараа мэдэгдэж байсан боловч Япон-манжийн тал энэ талаар арга хэмжээ авч зогсоох байтугай харин ч өдөөн хатгалгаа улам хүчтэй болгон гүтгэлгийн кампанит ажил өрнүүлснийг эрс эсэргүүцэн мэдэгдээд, БНМАУ-ын нутагт цөмрөн орсон цэргүүдээ даруй гэдрэг татаж авахыг хатуу шаардсан юм. Уг мэдэгдэлд хэрэв Япон-Манжийн зүгээс хангалттай хариу өгөхгүй буюу энэ мэтийн ажлыг дахин гаргах ахул БНМАУ-ын засгийн газар өөрийн мэдэлд байгаа бүх арга хэмжээ, зэвсэг хэрэглэх хүртэл арга хэмжээ авч хил хязгаараа эмх журамтай болгох явдлын бүрэн эрхийг өөрийн бие дээр үлдээнэ гэж тэдэнд сануулсны зэрэгцээ эл байдлыг дахин үргэлжлүүлбэл эцэстээ үлэмжхэн хүнд байдал тохиолдож болзошгүй тул түүний бүх хариуцлагыг Япон-Манжийн талд БНМАУ-ын засгийн газар бүрнээ хүлээлгэнэ гэж дурджээ.²

Гэвч 5-р сарын 28—29-ний өдрүүдэд Япон-Манжийн цэрэг танк, хуягт машин, их буу, үлэмжхэн тооны нисэх онгоцоор зэвсэглэж БНМАУ-ын нутагт дахин нэвтрэн орсон юм. Дайсны энэ халдлага Зөвлөлт-Монголын цэргийн ангиудад няцаагдаж, дайсан байлдааны газар олон тооны алагд-

¹ «Улаан од» сонин. 1939 оны 5-р сарын 22; «Ардын үндэсний эрх» сонин, 1939 оны 5-р сарын 23.

²Халх голын байлдаан. УБ., 1970, 84 дэх тал.

сан, шархдсан хүмүүс, буу зэвсгээ хаяж ухран зайлжээ. Халхын голын районд байлдааны ажиллагаа үргэлжилсээр байв.

ЗХУ-ын засгийн газар Японы түрэмгийлэгчдийн довтолгооныг зогсоохын тулд 1936 оны 3-р сарын 12-нд хоёр орны хооронд байгуулсан харилцан туслалцах Протокол гэрээний дагуу БНМАУ-д ихээхэн хэмжээний тусламж үзүүлэхээр яаралтай арга хэмжээ авсан юм.

Белоруссын цэргийн тойргийн жанжны орлогч, дивиз командлан захирагч Г. К. Жуков 1939 оны 6-р сарын 5-нд Тамсаг булагт ирж, төдхөн Халхын гол дахь байлдааны газар хүрэлцэн очиж удалгүй 57-р тусгай корпусын командлагчийн тушаалд томилогджээ.

Японы дайнчид 6-р сарын турш томоохон байлдаан хийх ажиллагаанд бэлтгэжээ.

Шинэ дайралт хийхийн өмнө тэд агаарт олон удаагийн ширүүн байлдаан явуулах болжээ. Агаарт тулалдах явдал бараг өдөр өнжихгүй шахам болдог байсан нь заримдаа агаарын томоохон байлдаан болтлоо ширүүсдэг ч байжээ. Жишээ нь, 6-р сарын 22-нд зөвлөлтийн 95 сөнөөгч онгоц японы 120 онгоцтой тулалдаж японы 30 гаруй онгоцыг устгажээ.¹ 6-р сарын 24-нд дайсны 16, 26-нд 10 онгоц тус тус устгажээ². Г. К. Жуковын бичсэнээр 6-р сарын 22-ноос 26-ныг дуусталх агаарын байлдаанд дайсан 64 онгоцоо алджээ³. 7-р сард ч агаарт томоохон байлдаан бас л болсоор байв. 7-р сарын 10-нд хоёр талаас 180 онгоц оролцсон ширүүн тулалдаан болж, дайсан 11 онгоцоо алджээ. 7-р сарын 21-нд японы 150 орчим сөнөөгч онгоц манай улсын хилийг зөрчин иржээ. Тэдний өмнөөс манай бас л тэр орчим тооны онгоц угтан нисч хоёр талаас нэг зэрэг 300 орчим онгоц тулалдаж байжээ. ЗХУ-ын маршал, Зөвлөлтийн цэргийн гарамгай жанжин Г. К. Жуковын бичсэнээр зөвхөн 7-р сарын 23-наас 8-р сарын 4-нийг хүртэлх хугацаанд дайсан 116 нисэх онгоцоо алдаж үүгээр агаарт ноёрхох гэсэн дайсны оролдлого амжилт олоогүй байна⁴. Түүнээс хойш зөвхөн тагнуулын нислэг хийж төв гарам, манай их бууны байрлал, нөөц хүчийг бага зэрэг бөмбөгдөх төдийгөөр хязгаарлах болжээ.

Японы цэрэг Халхын голын зүүн эрэгт байсан Зөвлөлт-Монголын цэргийг бүслэн устгах зорилгоор 7 дугаар сарын 2-нд давшжээ. Халхын голын байлдааны түүхэнд орсон Баянцагааны тулалдаан үүгээр эхэлжээ. Амжилт олно гэж их итгэлтэй байсан японы булаан эзлэгчид энэ районд гадаадын, түүний дотор Герман, Италийн сонин сурвалжлагчид, цэргийн атташе нарыг урьж ирүүлсэн байв.

7 дугаар сарын 2-нд давшсан японы цэрэг тэр шөнө Халхын голыг сэм гаталж, Баянцагааны нурууг эзэлжээ. Баянцагааны нуруунд 3 хоног тулалдахад хоёр талаас 400 орчим танк, хуягт машин, 300 гаруй их буу, хэдэн зуугаад нисэх онгоц оролцжээ. Энэ тулалдаанд Японы цэргийн цохилтын бүлэг бүрэн бутцохигдож, дайсан бараг бүх танк, их бууныхаа ихэнхийг алдаж, 45 онгоцоо устгуулж, 10 мянга орчим хүнээ алуулжээ. 7 дугаар сарын 8-нд Японы цэрэг дахин давшихыг оролдсон боловч 4 өдрийн ширүүн тулалдааны дараа 5500 хүнээ алуулж, шархдуулаад арга буюу ухран зайлжээ.

Японы милитаристууд өөрсдийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд Халхын голд 75 мянга гаруй цэрэг, офицер, 500 гаруй их буу, 182 танк, 350 орчим нисэх онгоц хуралдуулжээ. Эдгээр цэрэг ангийг 6 дугаар арми болгон зохион байгуулж генерал Огису Риппо гэгчийг командлагчаар

¹С. Н. Шишкин. Халх голд Зөвлөлт-Монголын армийн байлдааны ажиллагаа. 1939 он, УБ., 1954, 14 дэх тал.

²М. Новиков. Победа на Халхин-голе М. 1971. 41-р тал

³Г. К. Жуков. Дүртгал бодол. УБ., 1977. 171 дэх тал

⁴Г. К. Жуков. Дүртгал бодол. УБ., 1977, 176 дахь тал.

нь томилж, шийдвэрлэх давшилтаа 8 дугаар сарын 24-нд эхлэхээр төлөвлөсөн байжээ.

Зөвлөлт-Монголын цэргийн командлал БНМАУ-ын нутагт цөмрөн орсон Японы цэргийн хүчийг бүрэн устгах байлдаанд шаргуу бэлтгэжээ. 7 дугаар сарын 15-нд байлдааны газар байрлаж байсан Зөвлөлт-Монголын цэргийг шинэ нэмэгдэл хүчээр сэлбэж Армийн нэгдүгээр групп болгон зохион байгуулж командлагчаар нь ЗСБНХУ-ын Ардын Комиссаруудын Зөвлөлийн 1939 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн тогтоолоор корпусыг командлан захирагч цол авсан Г. К. Жуковыг томилжээ.

Энд Зөвлөлт-Монголын цэргийн нийт 57 мянган хүн, 498 танк, 385 хуягт машин, 542 их буу, миномёт, 2255 пулемёт, 515 нисэх онгоц хуралдсан байв¹.

Зөвлөлт-Монголын цэргийн давшилтыг 8-р сарын 20-нд гэнэт эхлэсэн явдал дайсны төлөвлөгөөг бүрэн нураажээ.

Тэр үеийн мэдээлэл, байлдаанд оролцогчдын бичсэн тэмдэглэл дурдатгалд бичсэнээс үзвэл 8 дугаар сарын 20-ны өглөөгүүр бороо орж тэнгэр бүрхэг байсан боловч 150 бөмбөгдөгч онгоц, 150 сөнөөгч онгоцны хамт агаарг хөөрч Японы бэхлэлт, их бууны анги, танкийн нэгтгэл, нисэх онгоцны буудлууд руу үхлийн ачаа буулгав. Дайсны эзэлсэн байрууд дээр тэсрэлтийн харанхуй манан бүрхэв² гэх зэргээр бичжээ. Зөвлөлт-Монголын их буучид гал нээв. Удсан ч үгүй «интернационал» дууллын эгшгийн дор явган цэрэг, танк, Зөвлөлт-Монголын морьт цэргийн ширүүн дайралт эхлэж дайсан эсэргүүцэл үзүүлэх чадалгүй болжээ. Японы офицерууд цэргээ буудан алахаар сүрдүүлж тулалдаанд хөөн оруулж байв. Гэвч атаклан дайрч байгаа Зөвлөлт-Монголын цэргийн түрэлт улам ихэссээр байв.

Тэр гайхамшигт өдрүүдэд түрэмгийлэгчдийг бутцоохихын төлөө дайны галд Зөвлөлт-Монголын армийн дайчин нөхөрлөлийн шинэ алтан хуудас бичигджээ. Наймдугаар сарын давшилтын үеэр зөвлөлтийн сөнөөгч онгоцууд анх удаа шинэ хүчит зэвсэг-пуужин хэрэглэжээ.

8-р сарын 23-нд нар шингэх үед Зөвлөлт-Монголын цэрэг дайсны бүлэглэлийг бүрэн бүслэж авсан байжээ. Бууж өгөхгүй байсан дайсныг бут ниргэхэд 5 өдөр шаардагджээ. Япончуудын бүгж байсан сүүлчийн өндөрлөгийг эзлэх тулалдаан 8-р сарын 28-нд болсон бөгөөд тэр өндөрлөг нь 7-р сарын 8-нд байлдаанд баатарлагаар нас барсан 149-р хорооны дарга И. М- Ремизовын дурсгалд зориулж нэрлэсэн Ремизовын өндөрлөг юм. Тэр өндөрлөгт бүгсэн япончуудыг тэр үед хурандаа байсан, хожим ЗХУ-ын баатар, БНМАУ-ын баатар, армийн генерал агсан И. И. Федюнинскийн командалсан мото-буудлагын 24-р хорооны дайчид атаклан дайрч бутцохиод 28-ны 23 цагт өндөрлөгийн оргилд ялалтын улаан туг мандуулжээ. 1939 оны 8-р сарын 31-ний өглөө БНМАУ-ын нутаг дэвсгэр дайснаас бүрэн цэвэрлэгдсэн байна. 9-р сарын 4, 8-ны өдрүүдэд япончууд Эрис уулын овооны чигт давшилт хийхийг оролдсон боловч амжилт олоогүй юм. 9-р сарын эхний хагаст 7 удаа агаарын тулалдаан болж, 9-р сарын 15-нд болсон хамгийн сүүлчийн томоохон тулалдаанд японы 120 сөнөөгч онгоц, Зөвлөлт-Монголын 200 сөнөөгч онгоц оролцоход японы 19 сөнөөгч онгоц устгагджээ.

1939 оны 5-р сараас 9-р сар хүртэлх хугацаанд япончууд 61 мянга гаруй хүнээ алуулж шархдуулан, олзлуулаад, 660 гаруй онгоцоо устгуулж, үлэмжхэн хэмжээний бусад зэвсэг техникээ алдсан юм. Мөн хугацаанд Зөвлөлт-Монголын цэргээс 18,5 мянган хүн амь үрэгдсэн буюу шархджээ. Зөвлөлт-Монголын армийн дайчид амь бие хайрлахгүй, хосгүй баа-

¹История второй мировой войны 1939—1945. т. П, М., 1974, 217-р тал

²М. Новиков. Победа на Халхин-голе. М., 1971, 79-р тал

тарлаг тулалдахын үлгэр жишээ үзүүлсэн юм. Монгол ардын хувьсгалт цэргийн олон зуун цэрэг дарга нар байлдаанд гавьяа байгуулсан учир засгийн газрын шагнал хүртсэн байна. Үүнд 6 дугаар дивизийн дарга Л. Дандар, 6 дугаар дивизийн 17-р хорооны байлдагч пулемётчин Ц. Олзвой нар 1939 онд, их бууны батарейн улс төрийн удирдагч Л. Гэлэгбаатар Халхын голын байлдааны ялалтын 25 жилийн ойгоор (Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1964 оны 9-р сарын 29-ний өдрийн зарлигаар) БНМАУ-ын баатар цол хүртэцгээсэн байна. Түүнчлэн Халхын голд японы булаан эзлэгчидтэй эрэлхэг баатарлаг байлдаж гавьяа байгуулсан учир Д. Гуулин, Д. Самдан, Ч. Дугаржав, Д. Хаянхярваа, Д. Нянтайсүрэн, Г. Чогдон, С. Төмөрбаатар, Н. Жамбаа нар удаа дараагаар БНМАУ-ын баатар цол хүртсэн билээ.

1939 оны 11-р сарын 18-нд «Правда» сонин «Баатар улаан арми» гэсэн тэргүүн өгүүлэлдээ «манай алдарт улаан армийн дайчид тэртээ Халхын голд үнэхээр эрэлхэг баатрын шилдэг үлгэр дууриал, эх орондоо, ленинизмийн үйл хэрэгт хязгааргүй үнэнчээ үзүүллээ» гэж онцлон тэмдэглэж байжээ. Үнэхээр ч зөвлөлтийн армийн үй олон дайчид БНМАУ-ын эрх чөлөө, тусгаар тогтнолыг сахин хамгаалж эрэлхэг зоригтой байлдаж мөнхийн гавьяа байгуулсан юм.

ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн 1939 оны 8-р сарын 29, 11 дүгээр сарын 17-ны өдрийн зарлигаар гарамгай гавьяа байгуулсан 70 гаруй дайчдад ЗХУ-ын баатар цол олгож, нисэгч С. И. Грицевец, Г. П. Кравченко, Я. В. Смушкевич нар ЗХУ-ын хошой баатар цол хүртэж Зөвлөлт Холбоот Улсын анхны хошой баатрууд болжээ¹. Зөвлөлтийн армийн 17121 дарга, улс төрийн ажилтан, байлдагч нарыг ЗСБНХУ-ын одон медалиар шагнажээ. Халхын голын дайчдын гавьяа зүтгэлийг засгийн газар өндөр үнэлж зөвлөлтийн армийн 326 дайчин, монголын ардын армийн 726 дайчдыг БНМАУ-ын одон медалиар шагнажээ.

Монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолыг хамгаалан бататгахад гарамгай их гавьяа байгуулж нийтийн дайсны эсрэг хамтран тулалдахад эрэлхэг баатар хатан зориг гаргаж, 1939 онд Халхын голд милитарист японы 6 дугаар армийг бүслэн, бут ниргэхэд Зөвлөлт-Монголын цэргийг маш чадамгай удирдсаныг тэмдэглэж, Халхын голын ялалтын 30 жилийн ойг тохиолдуулан, монгол дахь зөвлөлтийн цэргийн командлагч байсан Зөвлөлт Холбоот Улсын маршал Георгий Константинович Жуковт БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1969 оны наймдугаар сарын 12-ны өдрийн зарлигаар БНМАУ-ын баатар цол шагнажээ.

Мөнхийн гавьяат баатар дайчдын дурсгалд зориулж босгосон хөшөөнүүд Баянцагааны нуруу, Халхын гол дагуу, Чойбалсан хот зэрэг газруудад олон байдаг. Халхын голд болсон байлдаан бол Зөвлөлт-Монголын армийн байлдааны чадлыг шалгасан сүрхий сорилт болсон юм. Тэр шалгалтыг манай армиуд нэр төртэй давсан юм.

Зөвлөлт-Монголын цэргийн амьдрал практикт дайсны томоохон хүчийг тойрон бүслэж устгах байлдааны шинэ арга хэлбэрийг анх удаа хэрэглэсэн юм.

Халхын голын байлдааны ялалтын түүхэн ач холбогдлын тухай манай нам, улсын түүхэнд холбогдох баримт бичиг, нам, төрийн зүтгэлтэн нарын хэлсэн үгэнд яруу тод тусгагдсан юм. Халхын голын байлдааны ялалт нь юуны өмнө манай ардын хувьсгалт байгууллын давуутай тал, пролетарийн интернационализмын зарчимд тулгуурласан Монгол-Зөвлөлтийн ард түмний эвдрэшгүй найрамдлын аугаа их хүчин чадлын тод илрэл болсон юм. Үүнтэй холбогдуулан МАХН-ын Төв Хорооны тогтоолд «Халхын голын районд японы түрэмгийлэгчдийг ялсан Зөвлөлт-Монго-

¹ И. И. Кузнецов. Халхын голын баатрууд. УБ., 1978 он.

лын цэргийн яруу алдарт ялалтын 40 жилийн ойг монгол зөвлөлтийн ард түмэн, манай хоёр орны зэвсэгт хүчний ах дүүгийн эвдрэшгүй найрамдал, дайчин нөхөрлөлийн их баяр болгон тэмдэглэн өнгөрүүлэхээр»¹ заажээ.

МАХН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга БНМАУ-ын маршал Ю. Цэдэнбалын тодорхойлон хэлснээр Зөвлөлт-Монголын цэргийн Халхын голын ялалтын онц гарамгай ач холбогдол нь «Японы цэргийн командлалын удирдагчдыг сэнхрүүлж, тэднийг Зөвлөлт Холбоот Улсын эсрэг дайнд гитлерийн германы дараа орох төлөвлөгөөгөө эрэгцүүлэн бодож, хойшлуулахад арга буюу хүргэсэнд оршино»²

Халхын голын районд Японы эзэн хааны 6-р армийг бүслэн бутцохьсон нь Ази болон дэлхий дахиныг ноёрхох, эрмэлзлэл, төлөвлөгөөтэй байсан японы милитаризмд төдийгүй өнөө үеийн олон улсын байдлын ээдрээтэй нөхцөлд мөн тиймэрхүү санаархал тавин зорьж буй империалист харгис хүчин, бээжингийн эрх баригчдын эзлэн түрэмгийлэх явууллагад сүрхий сургамж болж байгаа юм.

Ялангуяа одоо үед империалист дайнд хамгийн харгис хүчинтэй холболдон сүлбэлдэж, их гүрний дээрэнгүй жанжлах үзэл, социализмын эсрэг, зөвлөлтийн эсрэг үзлийг үйл ажиллагаандаа удирдлага болгосон хятадын удирдагчид үнэн хэрэгтээ дэлхийн II дайны өмнө Ази тивийг эзлэн ноёрхох гэж байсан японы милитаристуудын замаар явж байна. Тэд ЗХУ манай орны эсрэг дэлхийн II дайны өмнөх японы дайнд барьж байгуулсан цэргийн бэхлэлт, зам гүүр, нисэх онгоцны буудал, харилцаа холбооны хэрэгслийг сэргээн босгосноос гадна ихээхэн хэмжээний цэргийн хүч, зэвсэг техникийг хуралдуулж, янз бүрийн тагнан турших явууллага, дайсагнасан суртал нэвтрүүлэг, зарим үед өдөөн хатгалга ч үйлдсээр байна.

Энэ бүхэн нь ЗХУ, манай улсын аюулгүй байдалд бодит заналхийллийг бий болгосон юм. Ийм нөхцөл байдал Зөвлөлт засгийн газар, БНМАУ-ын засгийн газрыг зүй ёсны эрс шийдвэртэй арга хэмжээ авахад хүргэжээ. Нөхөр Л. И. Брежнев тэргүүтэй зөвлөлтийн нам-засгийн төлөөлөгчдийн 1966 оны 1-р сард БНМАУ-д хийсэн албан ёсны нөхөрсөг айлчлалын үеэр БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд байгуулсан найрамдал, хамтын ажиллагаа, харилцан туслах гухай гэрээний дагуу манай улсын засгийн газрын хүсэлтээр тус оронд зөвлөлтийн цэргийн ангиудыг байрлуулах болсон юм.

Бээжингийн маоист удирдлага улс орноо яаравчлан цэрэгжүүлж, хөрш зэргэлдээ орнуудаа дайсагнасан ажиллагаа явуулан, тэдний газар нутагт өнгөлзөж, тэднийг эзлэн түрэмгийлэх бодлогоо хэрэгжүүлэхийг эрмэлзэж байгаа нь энэ оны хавар Социалист Вьетнамын эсрэг үйлдсэн зэвсэгт түрэмгийллээс тодорхой харагдаж байна.

Мөн иймэрхүү бодлогыг бээжингийн дайны хэнээтнүүд манай улсын хувьд хэрэгжүүлэхийг эрмэлзэж байна. Тэд уг зорилгодоо хүрэхийн тулд манай засгийн газартай урьдчилан ярилцалгүйгээр зөвлөлтийн цэргийн ангиудыг БНМАУ-аас гаргахыг ЗХУ-д шаардсан зүй бус явууллага үйлдсээр байна. Үүнтэй холбогдуулан нөхөр Ю. Цэдэнбал МАХН-ын Төв Хорооны VII бүгд хурал дээр хэлэхдээ: «Хятадын эрх баригчид...улс хоорондын гэрээний үндсэн дээр манай оронд байгаа зөвлөлтийн цэргийн ангиудыг БНМАУ-ын нутгаас гаргахыг зүй бусаар шаардаж байна...БНМАУ-ын тусгаар тогтнол, бүрэн эрхэд бээжингийн эрх баригчдын зүгээс бодитойгоор заналхийлж байна гэж шууд хэлж болно. Энэ

¹«Үнэн» сонин, 1979. II 10.

²«Үнэн» сонин, 1979. VIII 20.

аюул занал арилаагүй цагт бид өөрийн социалист эх орны тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хамгаалах үйлсдээ урьдын адил Зөвлөлт Холбоот Улсын тусламжийг авах явдал зүй ёсны хэрэг юм»¹ гэсэн билээ.

Манай орны эрх чөлөө, тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдалд заналхийлж байгаа хятадын эрх баригчид Халх голын дайнд японы 6-р арми бутцохигдож, дэлхийн 2-р дайнд германы фашизм, японы милитаризм ялагдсан түүхэн сургамжаас ухааран, өөрийн айл зэргэлдээ орнууд, Ази болон даян дэлхийн улс түмний энх тайван, аюулгүй байдлын эсрэг бодлогоосоо татгалзах нь юуны өмнө хятадын олон зуун сая хөдөлмөрчин ард түмний амин чухал эрх ашигт нийцэхсэн билээ.

Д. Цэдэв

ИСТОРИЧЕСКАЯ ПОБЕДА СОВЕТСКО- МОНГОЛЬСКИХ ВОЙСК НА РЕКЕ ХАЛХИН-ГОЛ

Р е з ю м е

Статья посвящена 40-летию победы советско-монгольских войск над японскими захватчиками на реке Халхин-гол.

Со времени оккупации Маньчжурии японская военщина неоднократно устраивала вооруженные провокации на восточной границе МНР. Сконцентрировав там крупные контингенты войск, японские милитаристы в мае 1939 г. начали активные боевые действия против МНР. Японское командование рассчитывало в кратчайший срок захватить Монгольскую Народную Республику, но планы японских самураев были сорваны решительными боевыми действиями советско-монгольских войск. В итоге четырехмесячных жестоких сражений 6-я императорская армия Японии была разбита.

Автор статьи на основе архивных материалов и воспоминаний участников халхингольских боев подробно останавливается на ходе военных операций советско-монгольских войск. В статье даются данные о численности войск, принявших участие в сражениях с обеих сторон, о военной технике и боеприпасах, использованных в боях у реки Халхин-гол.

Особо подчеркивается, что именно нерушимая братская дружба советского и монгольского народов, боевое содружество их армий, неоценимая бескорыстная помощь Советского Союза Монгольской Народной Республике явились решающим фактором исторической победы, одержанной над японскими самураями в районе реки Халхин-гол. Победа над самураями сорвала захватнические планы не только японской военщины, но и международной империалистической реакции.

Историческая победа советско-монгольских войск над японскими захватчиками в районе реки Халхин-гол имеет особую актуальность и в наши дни, когда вновь возрождается японский милитаризм, когда пекинские лидеры, блокируясь с реакционными империалистическими кругами Запада и Японии, осуществляют форсированную милитаризацию страны и всячески активизируют открыто враждебную политику в отношении СССР,

1 «Үнэн» сонин, 1979 оны 11-р сарын 20.

МНР и других стран социалистического содружества, нагнетая международную напряженность в Азии и во всем мире.

Политика и деятельность нынешнего китайского руководства на международной арене, в частности на Дальнем Востоке и в Азии, представляет собой реальную угрозу свободе и независимости соседних с Китаем стран, о чем свидетельствует его вооруженная агрессия против социалистического Вьетнама весной 1979 г.

Автор также анализирует великодержавно-шовинистическую политику пекинских лидеров в отношении нашей страны. Китайские лидеры не только восстанавливают построенные японскими милитаристами до второй мировой войны военные укрепления и вновь строят дороги, мосты, военные аэродромы и линии связи, но и сосредотачивают большое количество войск и военной техники на своих границах с МНР и СССР. Наряду с этим китайской стороной ведется широкая шпионско-диверсионная деятельность, враждебная пропаганда против СССР и МНР, время от времени устраиваются провокационные действия на наших границах.

Все это, как подчеркивает автор, вынудило правительства СССР и МНР принять соответствующие меры по укреплению безопасности своих границ. Согласно Договору о дружбе, сотрудничестве и взаимной помощи между СССР и МНР, заключенному в январе 1966 г., по просьбе нашего правительства находятся советские воинские части в МНР. Однако пекинские руководители в целях своей захватнической политики в отношении нашей страны незаконно требуют от Советского Союза вывода советских воинских частей из МНР.

По этому поводу, как заявил тов. Ю. Цеденбал, угроза независимости и суверенитету МНР со стороны пекинских властей существует реально и пока эта угроза не устранена, мы по-прежнему будем нуждаться в эффективной помощи Советского Союза в деле защиты независимости и безопасности нашей социалистической родины.